

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГДАР ГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ЖАРГАЛСАЙХАН



УДИРДАМЖ

2025 оны 04 дүгээр сарын 14

Чингис хот

Бодлогын баримт бичгийн төлөвлөлт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай

Зорилго: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, захиргааны байгууллагын
үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөн туслах

Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 23-аас 2025 оны 04 дүгээр сарын 29-ийг
хүртэл

Ажиллах хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Саруултөгс	Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
	Б.Ундрахжаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн
	Д.Мягмарбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Хамрах хүрээ: Мөрөн, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Жаргалтхаан,
Өмнөдэлгэр

Хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

- 1.Бодлогын баримт бичгийн төлөвлөлт
- 2.Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн
төлөвлөгөө, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо
- 3.Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, түүний ажлын
төлөвлөлттэй уялдсан байдал
- 4.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр батлагдсан бүтэц,
орон тооны дагуу ажиллаж байгаа эсэх

5.Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулсан (төрийн албаны тусгай шалгалт өгсөн), томилсон шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

6.Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулсан (төрийн албаны ерөнхий, тусгай шалгалт өгсөн), томилсон шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

7.Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

8.Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

9.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалыг бууруулж томилсон, төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

10.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан дүгнэлт гаргуулаагүй иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон эсэх

11.Төрийн албаны тухай хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэх

12.Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг шалгах (төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоосон баримт болох төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн баримт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн шийдвэр, төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргийн хуудас)

13.Захирамж, тушаал хянах

14.Эрх зүйн хөтөч булангийн ашиглалт

Жич: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлж дүгнэнэ.

Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.УЯНГА